

**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**

**ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар: *22/01/02* Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ**  
**ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.4 дахь заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.1 , 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4-р сарын 04-ний өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 3-р сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
  1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
  2. Компанийн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
  3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
  4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнах
  5. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2022 оны 2 дугаар сарын 23-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2022 оны 3-р сарын 14-нд уг зарыг давтан, 2022 оны 2-р сарын 28-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 4-р сарын 04-ний өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2022 оны 3-р сарын 15 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /У.Анар/-т даалгасугай.

8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г.Халиунаа, гишүүнээр Б.Отгонтуяа, Тооллогын комиссийн даргаар, гишүүнээр Х.Мөнгөнцэцэг, гишүүнээр О.Мэндбаяр нарыг тус тус томилсугай.
10. “Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**Р.ОТГОНБАТ**